

**САНГИЙН ЯАМ  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР**


**Хадгаламжийн даатгалын корпорацийн санхүү,  
аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн  
шалгалтын материал**

**Шалгалтанд хамрагдсан хугацаа: 2016 он, 2017 оны  
эхний хагас жил**

**Шалгалт эхэлсэн:  
Шалгалт дууссан:**

**2017.11.08  
2017.12.11**

**Шалгасан: Санхүүгийн хяналт шалгалтын,  
улсын ахлах байцаагч:  Д.Гэрэл**

**Улсын байцаагч:  Б.Энхтуяа**



**Хуудасны тоо 34**

**Улаанбаатар хот  
2017 он**

## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

### САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 12 дугаар сарын 18

#### **Нэг. Шалгалтын зорилго, бүрэлдэхүүн**

Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас Хадгаламжийн даатгалын корпораци сан /цаашид ХДК сан гэх/-гийн 2016 он, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжид төрөөс баталгаа гаргах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай зэрэг хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль эрх зүйн акт, дүрэм, журмын мөрдөлт хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд шалгалтын зорилго чиглэгдлээ.

Шалгалтыг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Гэрэл, улсын байцаагч Б.Энхтуяа нар хийж гүйцэтгэлээ.

#### **Байгууллагын зорилго үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин**

- Монгол Улсын Их Хурлын 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн чуулганаар “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийг хэлэлцэн батлан, уг хууль хэрэгжиж эхэлжээ.

Дээрх хууль нь банкны мөнгөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоож, хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой байна.

- Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн “Хадгаламжийн даатгалын корпораци байгуулах тухай” 2013 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 76/A-66 тоот хамтарсан тушаалаар Үндэсний хорооны бүрэлдэхүүн, Монголын Хадгаламжийн даатгалын корпорацийг байгуулах, Хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгох ажлын нэгдсэн төлөвлөгөө зэргийг баталжээ.

- Сангийн сайд, Монголбанкны өрөнхийлөгчийн 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А-106/118 тоот тушаалаар “Хадгаламжийн даатгалын корпорацийн дүрэм”, “Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны ажиллах журам”-ыг тус тус баталсан байна.
- Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны 2014 оны 17 тоот тогтоолоор “Хөрөнгө оруулалтын бодлого”-ыг батлан, мөрдөн ажилласан байна.
- Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.3-т заасны дагуу 2013 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор “Банкны тайлан болон мэдээ, мэдээлэл ирүүлэх журам”-ыг баталж, журмын дагуу банкууд тайлангаа ирүүлж, тэдгээрийг нягтлах үүднээс ХДК нь Монголбанкнаас банкуудын санхүүгийн тайлангийн зөвхөн эх үүсвэрийн буюу пассив талын мэдээллийг сар бүр хүлээн авч, тулгасны үндсэн дээр улирлын хураамжийн хэмжээг тооцдог байна.
- “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.1-д хадгаламжийн даатгалын “Хураамжийн журам”-ыг Үндэсний хороо батлахаар заасны дагуу Үндэсний хорооны 2016 оны 12 дугаар сарын 26-ны 08 тоот тогтоолоор баталсан бол 2017 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 37 дугаар тогтоолоор тус журамд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.
- ХДК-ийн гүйцэтгэх захирлын 2013 оны 11 тоот тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг баталж, 2016 оны 4 дүгээр сарын 15-ны 16 тоот тушаалаар шинэчлэн батлан, мөрдөж байна

Хадгаламжийн даатгалын корпораци нь “Сан”-гийн хэлбэрээр зохион байгуулагдсан, ашгийн төлөө бус, төрийн өмчит хуулийн этгээд бөгөөд “Банкны тухай хууль”, “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-уудад заасны дагуу банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банкин дахь харилцах болон хадгаламжийн дансны мөнгөн хөрөнгийг албан журмын даатгалд хамруулах, даатгалын хураамжийг төвлөрүүлэх, даатгалын санг хөрөнгө оруулалт хэлбэрээр ёсгөх, Монгол банкнаас албадан татан буулгах шийдвэр гаргасан банкны хадгаламж өзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөр төлөх зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна.

“Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Хадгаламжийн даатгалын сангийн удирдлагыг Хадгаламжийн даатгалын корпораци хэрэгжүүлнэ”, мөн хуулийн 10.2-т сангийн эх үүсвэрийн бүрэлдэхүүнүүдийг тодорхойлж өгчээ.

Хадгаламжийн даатгалын корпорацийн удирдах дээд байгууллага Үндэсний Хороо нь “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 22 дугаар зүйлийн 22.2.1-д зааснаар Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч нь Үндэсний хорооны гишүүн бөгөөд даргаар, Сангийн яамнаас 2, Монгол банк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Банкны Холбооноос тус бүр 1 төлөөлөгч, Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирал гэсэн 7 гишүүнтэйгээр Корпорацийн бүтэц, үйл ажиллагааны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах, үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй ажилладаг байна.

“Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 27 дугаар зүйлийн 27.3-д “Корпорацийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд хоёр жилд нэгээс доошгүй удаа Үндэсний хорооноос сонгосон олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар аудит хийлгэж, дүгнэлтийг Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна” гэж заажээ.

Корпорацийн 2016 оны санхүүгийн тайланд Прайсуотерхаускуперс-Аудит /PWC/ ХХК аудит хийж, “Монголын Хадгаламжийн даатгалын корпорацийн санхүүгийн тайлангууд нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, мөн тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагнналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна” гэсэн дүгнэлт өгсөн байна.

Мөн тус корпораци нь Сангийн яаманд хэрэгжиж буй Дэлхийн банкны Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл /Multi-Sectoral Technical Assistance Project/-ийн шугамаар зөвлөх үйлчилгээ болон Хадгаламжийн даатгалын 16 үндсэн зарчмаар үйл ажиллагааг үнэлүүлэх туслалцаа авч, хамтран ажиллажээ.

Тус корпораци нь Олон улсын Хадгаламжийн даатгагчдын холбоо /IADI/-ны 72 дахь үндсэн гишүүнээр элссэн бөгөөд тус холбооноос шалгаруулдаг дэлхийн шилдэг байгууллагаар 2014 онд Монголын ХДК шалгарсан байна. Түүнчлэн бусад улсын ижил төстэй байгууллагуудтай харилцан туршлага судлан, Олон улсын хадгаламжийн даатгагчдын холбооноос гаргасан “Үр дүнтэй хадгаламжийн даатгалын системийн үндсэн зарчим” зөвлөмж, зааварчилгааг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж иржээ.

Хадгаламжийн даатгалын корпорацийн 2016 оны жилийн эцсийн болон 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын тушаалаар баталсан заавар журам, аргачлалыг баримтлан санхүүгийн тайлагнналын олон улсын стандарт /СТОУС/-ын

дагуу хуулийн хугацаанд нь тайлагнаж, Чингэлтэй дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэст тушааж, "Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль"-ийн 27 дугаар зүйлийн 27.6-д: "Энэ хуулийн 27.1-д заасан тухайн жилийн тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний дотор Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнана" гэж заасны дагуу тус байгууллагуудад хургуулсан байна.

Хадгаламжийн даатгалын корпораци /сан/-ийн гүйцэтгэх захирлаар Б.Лхагвасүрэн 2013 оны 05 дугаар сарын 08-аас 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл ажиллан, 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс корпорацийн Тамгын хэлтсийн хуульч, ахлах мэргэжилтэн Б.Амарбилэгийг түр, Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны 2016 оны 28 тоот тогтоолоор 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс Х.Бум-Эрдэнийг гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр, Үндэсний хорооны 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 32 тоот тогтоолоор гүйцэтгэх захирлаар томилсон байна.

ХДК-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон корпорацийн орлого, зардлын төсвийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлж тогтоолоор шийдвэрлүүлж иржээ.

Корпорацийн санхүүгийн баримтад нэгдүгээр гарын үсгийг гүйцэтгэх захирал Б.Лхагвасүрэн 2016 оны 9 дүгээр сарын 1 хүртэл, Б.Амарбилэг 2016 оны 11 дүгээр сарын 01 хүртэл, Х.Бум-Эрдэнэ 2016 оны 11 дүгээр сарын 1-ээс одоог хүртэл, гарын үсгийн хоёрдугаарыг ерөнхий /ахлах/ няглан бодогч Г.Бат-Эрдэнэ нар захиран зарцуулж иржээ.

ХДК-ын дансны үлдэгдлийг банкуудаар харуулбал:

/төгрөгөөр/

	Банкууд	Данс		2016.01.01	2016.12.31	2017.01.01	2017.06.30
1	Голомт банк	1140000639	MNT	18,205,924.10	20,627,282.04	20,627,282.04	25,669,592.44
2	Голомт банк	1175102851	MNT	197,122.19	449,945.43	449,945.43	495,019.93
3	Голомт банк	1105076502	MNT				
4	Хас банк	5001580225	MNT	79,602,637.89	290,988.88	290,988.88	284,988.88
5	Хас банк	5000964259	MNT	38,827,047.78	79,768,749.32	79,768,749.32	57,148,642.65
6	Чингис хаан банк	3941110001	MNT	11,938,668.69	86,267,108.93	86,267,108.93	69,276,590.78
7	Төрийн банк	106000024285	MNT	70,248,525.82	55,703,169.90	55,703,169.90	42,955,408.67
8	Төрийн банк	346900201391	MNT				
9	Төрийн банк	106000024396	USD	-			
10	Монгол банк	3603006		1,971,589,420.47	2,931,362,899.94	2,931,362,899.94	2,491,221,502.13
11	Улаанбаатар хотын банк	2600080288	MNT	8,820,870.47	734,053.91	734,053.91	20,634,773.08
12	Капитрон банк	3053012309	MNT	412,285,219.86	21,291,147.44	21,291,147.44	35,462,160.93
13	Капитал банк	2000029040	MNT	43,206,505.64	66,008.77	66,008.77	60,008.77
14	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	2900004293	MNT	333,482,331.78	15,305,879.52	15,305,879.52	32,854,060.54
15	ХААН банк	5014416611	MNT	-	29,783,760.82	29,783,760.82	64,721,122.54

16	Тээвэр хөгжлийн банк						
17	БИДИСЕК ҮЦК			3,199.79	-	-	69,287.94
	Нийт дансны үлдэгдэл			2,988,407,474.48	3,241,650,994.90	3,241,650,994.90	2,840,853,159.28

Хоёр. Хадгаламжийн даатгалын сангийн орлого, зардлын талаар.

### 2.1. Сангийн эх үүсвэр, орлогын талаар

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн "Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль"-ийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 06 тоот тогтоолд сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд шаардлагатай 100.0 тэрбум төгрөгийн 50.0 тэрбум төгрөгийг Засгийн газраас, Монголбанкнаас 50.0 тэрбум төгрөгийг тус тус гаргахаар шийдвэрлэжээ.

Мэн 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр баталсан "Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль"-ийн 2.5-д заасан шимтгэлийг төвлөрүүлж, төвлөрсөн хөрөнгийг дээрх хуулийн 19.5-д заасны дагуу Монголбанкинд нээсэн Хадгаламжийн даатгалын корпорацийн дансанд 2013 оны 8 дугаар сарын 01-ний дотор шилжүүлэхийг Засгийн газар, Монголбанкинд тус тус даалгасаны дагуу Монголбанкнаас 2013 онд 50.0 тэрбум төгрөг, Засгийн газраас 2013 онд 35.0 тэрбум төгрөг, 2014 онд 7.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг ХДК-ийн эх үүсвэрт шилжүүлжээ.

Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны 2015 оны 24 тоот тогтоолоор корпорацийн 2016 оны нийт орлогыг 47.4 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 61.4 тэрбум төгрөг буюу 13.9 тэрбум төгрөгөөр илүү төвлөрүүлж, Үндэсний хорооны 2016 оны 29 тоот тогтоолоор 2017 оны нийт орлогыг 62.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс эхний хагас жилд 37.3 тэрбум төгрөгийн орлогыг оруулсан байна. Үлдсэн хугацаанд жилийн эцсийн орлого өмнөх онуудын мөн үеийн гүйцэтгэлээс харахад хөрөнгө оруулалтын өгөөж 42.8 тэрбум, даатгалын хураамжаар 36.0 тэрбум төгрөг буюу нийт 78.8 тэрбум төгрөгийн орлогыг оруулахаар байна.

ХДК сангийн орлого зарлагыг харуулбал:

/сая төгрөгөөр/

Эх үүсвэр болон орлого	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017. 06.30	ДҮН
Монголбанкнаас оруулсан хөрөнгө	50,000.0					50,000.0
Засгийн газраас оруулсан хөрөнгө	35,000.0	7,194.1				42,194.1
Эх үүсвэрийн дүн	85,000.0	7,194.1				92,194.1
Хөрөнгө оруулалтын орлого	1,711.0	14,293.0	23,461.8	29,809.8	20,457.6	89,733.2
Хураамжийн орлого	19,199.1	33,155.7	27,396.4	31,564.7	16,906.2	128,222.2
Орлогын дүн	20,910.1	47,448.7	50,858.2	61,374.5	37,363.8	217,955.4
Сангийн нийт орлого	105,910.1	54,642.8	50,858.2	61,374.5	37,363.8	310,149.4

Хөрөнгө оруулалтын зардал	30.3	540.2	655.0	1,162.0	776.6	3,164.2
Үйл ажиллагааны зардал	258.0	1,202.3	1,572.8	2,037.4	1,218.0	6,288.6
Монгол банкны эээлийн хүүгийн зардал	153.2	599.5	601.0	596.5	283.2	2,233.3
Зардлын дүн	441.5	2,342.0	2,828.8	3,795.9	2,277.8	11,686.1
Сангийн нийт хөрөнгө	105,468.6	52,300.8	48,029.4	57,578.6	35,086.0	298,463.3

Хадгаламжийн даатгалын корпораци нь 2013 онд 85.0 тэрбум төгрөгийн эхлэлтийн хөрөнгөтэй үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт орлого 298.4 тэрбум төгрөгт хүрч өссөн бөгөөд үүнээс хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаар 89.7 тэрбум төгрөг, хураамжийн орлогоор 128.2 тэрбум төгрөг, Засгийн газраас 7.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийн үлдэгдэл зэрэг орлогыг санд тус тус төвлөрүүлсэн байна.

### **2.1.1. Хадгаламжийн даатгалын хураамжийн орлогын талаар**

“Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо нь жил бүрийн 11 дүгээр сарын 30-ны дотор банкуудаас авах дараа жилийн улирлын хураамжийн хувийг 0.125 хувиас хэтрүүлэхгүй хэмжээгээр тогтооно” гэж заасан байна. Үндэсний хороо нь 2013 оноос хойш 4 удаа хадгаламжийн даатгалын хураамжийн хувийг өөрчлөн тогтоол гаргасан байна. Үүнд:

- 2013 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 06 тоот тогтоолоор банкуудаас авах улирлын хураамжийн дээд хэмжээг хуулинд зааснаар буюу 0.125 хувиар,
- 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 10 тоот тогтоолоор жилийн хураамжийн хувийг банкны системийн нөлөө бүхий банкууд /Төрийн банк, ХХБ, Голомт, ХААН, Хас банкнаас 0.3 хувиар /улирлын 0.075 хувь/, бусад банкуудаас 0.4 хувиар /улирлын 0.1 хувиар/
- 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 20 тоот тогтоолоор жилийн хураамжийн хувийг системийн нөлөө бүхий банкуудаас 0.25 хувиар /улирлын 0.0625 хувиар/, бусад банкуудаас 0.35 хувиар /улирлын 0.0875 хувиар/,
- 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 23 тоот тогтоолоор хураамжийн хувийг бүх гишүүн банкуудад ижил суурьтай буюу жилийн 0.25 хувиар /улирлын 0.0625 хувиар/ тус тус баталсныг мөрдөн хадгаламжийн даатгалын хураамжийг тооцон авсан байна.

“Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.5-д “тухайн улирлын хураамжийн хэмжээ нь өмнөх улирлын дундаж үлдэгдэлд үндэслэнэ” гэж заасны дагуу 2016, 2017 оны эхний хагас жилд арилжааны 14 банкнаас Хадгаламжийн даатгалын санд нийт 46.5 тэрбум төгрөгийн хадгаламжийн даатгалын хураамжийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Мөнгөн хадгаламжийн даатгалын хураамжийн ногдуулалт барагдуулалтыг харуулбал:

/сая.төгрөгөөр/

		2016 он		2016 он эцсийн үлдэгдэл		2017 он эхний хагас жил		2017.06.30 эцсийн үлдэгдэл	
№	Харилцагч банк	ногдуулалт	төлсөн	ногдуулалт	төлсөн	ногдуулалт	төлсөн	ногдуулалт	төлсөн
1	Үндэсний хөрөнгө оруулалтын	300.4	300.4	0.0	0.0	203.1	203.1	0.0	-
2	Ариг	168.0	168.0	0.0	0.0	80.8	80.8	0.0	-
3	Кредит	1.3	1.3	0.0	0.0	0.3	0.3	0.0	-
4	Капитал	929.8	929.8	0.0	0.0	500.8	500.8	0.0	-
5	Төрийн банк	3,297.2	3,297.2	0.0	0.0	1,808.6	1,808.6	0.0	-
6	ХААН	9,052.2	8,021.0	1,031.2	0.0	4,851.6	4,851.6	1,031.2	-
7	Чингис хаан	325.8	325.8	0.0	0.0	228.4	28.4	0.0	-
8	Голомт	6,579.9	5,676.5	903.5	0.0	3,380.4	3,414.0	869.9	-
9	Тээвэр хөгжлийн	0.3	0.3	0.0	0.0	0.2	0.2	0.0	-
10	Капитрон	375.0	375.0	0.0	0.0	377.8	377.8	0.0	-
11	Хас	2,340.7	2,340.7	0.0	0.0	1,270.8	1,270.8	0.0	-
12	Улаанбаатар	2,092.8	2,092.8	0.0	0.0	1,129.0	1,129.0	0.0	-
13	Худалдаа хөгжлийн	6,034.3	6,034.3	0.0	0.0	3,037.4	3,037.4	0.0	-
14	Богд	67.0	66.4	0.5	0.0	37.0	37.6	0.0	-
Нийт дүн		31,564.7	29,629.5	1,935.2	0.0	16,906.2	16,940.3	1,901.1	-

ХААН, Голомт банкууд 2016 онд нийт 1,901.1 сая төгрөгийн хураамжийн төлбөрийг төлөөгүй байгаа нь дээрх 2 банкин дахь Хөгжлийн банкны харилцах хадгаламжаас авах даатгалын хураамж байгаа бөгөөд “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 7.2-т заасан “даатгалд хамаарахгүй” гэсэн заалттай /заалтад хамаарахгүй/ холбон хураамжийг төлөөгүй байна.

Монгол улсын Хөгжлийн банк нь томоохон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилго бүхий тусгайлсан чиг үүрэгтэй ашгийн төлөө Төрийн өмчит хуулийн этгээд бөгөөд хүүгийн ашиг олох зорилгоор арилжааны банкуудтай “Мөнгөн хадгаламжийн гэрээ” хийж, төслийн зээлийн хөрөнгийг хадгаламж хэлбэрээр байршуулдаг.

Иймд “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 3.1.4-т “хадгаламж” гэж Банкны тухай хуульд заасан харилцах болон мөнгөн хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгийг”, мөн хуулийн 13.5-д заасны дагуу дээрх 2 банкнаар хураамжийг төлүүлэх нь зүйтэй байна.

ХДК-тай харилцагч банкуудад байршиж буй хадгаламжийн үлдэгдэл 2017 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар 12.5 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Харилцагч банкуудад байршиж буй харилцах, хадгаламж дансны үлдэгдлийг харуулбал:

Үзүүлэлт	2016 оны эцсийн үлдэгдэл	2017.06.30-ны үлдэгдэл
<b>Иргэд дүн</b>	<b>8,324,395.9</b>	<b>8,855,324.6</b>
20 сая хүртэл	2,270,482.5	2,536,043.4
20 саяас 30 сая хүртэл	441,201.5	475,930.1
30 саяас 40 сая хүртэл	317,667.9	349,766.5
40 саяас 50 сая хүртэл	269,836.6	295,345.7
50 саяас 100 сая хүртэл	977,217.0	1,046,410.5
100 саяас дээш	4,047,990.4	4,151,828.8
<b>Хуулийн этгээд дүн</b>	<b>3,256,615.9</b>	<b>3,686,663.2</b>
20 сая хүртэл	86,908.7	91,882.2
20 саяас 30 сая хүртэл	24,848.0	28,078.9
30 саяас 40 сая хүртэл	21,489.9	25,509.3
40 саяас 50 сая хүртэл	19,180.9	22,961.9
50 саяас 100 сая хүртэл	78,148.3	81,111.0
100 саяас дээш	3,026,040.1	3,437,119.8
<b>Хуулиар даатгалд хамрагдахгүй дүн</b>	<b>2,097,107.6</b>	<b>2,514,244:1</b>
Банк	752,217.9	848,852.9
Төрийн байгууллага	431,641.2	475,828.0
Нийгмийн даатгалын сан	768,626.0	810,025.5
Холбогдох этгээд	122,462.8	121,545.2
Аудит	341.8	836.9
Хуулийн 7.2.6.а, 7.2.6.б	21,818.0	18,176.7
Хуулийн 7.1-т заасан		238,978.8
<b>Нийт</b>	<b>13,678,119.4</b>	<b>15,056,231.9</b>

Тус корпораци харилцагч банкинд санхүүгийн хүндрэл учирсан тохиолдолд хадгаламж өзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор сангийн хөрөнгөө өсгөн нэмэгдүүлэх, цаашлаад гарч болзошгүй эрсдлээс хамгаалах зорилгоор хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд Олон улсын валютын сангаас Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудад актив хөрөнгийн үнэлгээ хийгдэж байна.

Мөн шаардлагатай тохиолдолд “Санхүүгийн дэмжлэг туслалцаа авах тухай” Монголбанктай 2017 оны 5 дугаар сарын 30-ны 02 тоот, Сангийн яамтай 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 01 тоот санамж бичгийг тус тус үйлджээ.

Дээрхи хоёр эх үүсвэрээс санхүүгийн дэмжлэг авах асуудалд хүндрэл учирсан тохиолдолд гадаадын банк, санхүүгийн байгууллагаас зээл авах шаардлага үүсэх нөхцөл гарч болзошгүй гэж үзэн 2017 оны 1 дүгээр сард Европын Сэргээн босголтын банк (EBRD)-д зээлийн шугам нээлгэн хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлж, тус банктай корпорацийн удирдлага болон Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын хэмжээнд хэд хэдэн удаагийн уулзалтыг хийснээс гадна зээлийн нөхцөлийн талаарх саналуудыг солилцсон хэмжээнд ажилласан байна.

### **2.1.2. Сангийн үнэт цаасны арилжааны орлогын талаар**

“Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 12 дугаар зүйлд ХДК сангийн актив хөрөнгийг аюулгүй, хөрвөх чадвартай, ашигтай байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд байршуулж болно гэж зааснаар Монгол банкны үнэт цаас, Засгийн газрын бондыг худалдан авч, Төв банкны үнэт цаасыг арилжааны банкуудаар, Засгийн газрын үнэт цаасыг Үнэт цаасны төлбөр тооцоо хадгаламжийн төвөөр дамжуулан арилжаалж байна.

“Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 12.1-д “Хадгаламжийн даатгалын корпораци Сангийн актив хөрөнгийг аюулгүй, хөрвөх чадвартай, ашигтай байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд байршуулж болно”, 12.1.1-д “Засгийн газраас гаргасан болон батлан даасан үнэт цаас”, 12.1.2-т “Монголбанкны үнэт цаас”, 12.1.3-т “зээлжих зэрэглэл тогтоодог нэр хүнд бүхий олон улсын байгууллагаас ААА-аас доошгүй үнэлгээ авсан гадаад улсын Засгийн газрын болон олон улсын санхүүгийн байгууллагын үнэт цаас”, 12.1.4-т “олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банкинд нээсэн хадгаламж”, 12.2-т “Хадгаламжийн даатгалын корпорацийн хөрөнгө оруулалтын журам, заавар болон хөрөнгө оруулалтын бодлогыг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална” гэж тус тус заажээ.

Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны 2014 оны 10 сарын 23-ны өдрийн 17 тоот тогтоолоор “Хадгаламжийн даатгалын корпорацийн сангийн хөрөнгө оруулалтын бодлого”-ыг баталсан байна. “Хөрөнгө оруулалтын бодлого”-ын 4.1.1-д “Монгол улсын Засгийн газраас гаргасан болон батлан даасан үнэт цаас, Монгол банкны үнэт цаасанд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ Сангийн хөрөнгө оруулалтын багцын нийт дүнгийн 90 хувиас багагүй байна”, 4.1.3-т “тус сангийн Монгол банкин дах харилцах дансны өдөр бүрийн дундаж үлдэгдэл сангийн актив хөрөнгийн 1 хувиас багагүй байна, хөрөнгө оруулалтын багц нь хөрвөх чадвар

сайтай, төлөгдөх хугацаа нь холимог, жигнэсэн дундаж хугацаа 5-10 жил байх” зэргийг тус тус заажээ.

Үүний дагуу ХДК 2013 онд Монголбанкнаас оруулсан эхлэлтийн хөрөнгө болох 50.0 тэрбум төгрөгийг Голомт банк болон Хас банкаар зуучлуулан Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-нд байршуулсан байна.

Мөн 2013 оны 10 дугаар сард Чингис хаан банктай “Хөрөнгө оруулалтын зуучлалын гэрээ” байгуулж, Төв банкны үнэт цаас /ТБҮЦ/-нд сангийн хөрөнгийг хуваан байршуулжээ.

Мөн 2013 оны 4 дүгээр улиралд Сангийн яамнаас 35.0 тэрбум төгрөгийн эхлэлтийн хөрөнгө орж ирсэнийг мөн оны 12 дугаар сараас Төрийн банктай зуучлалын гэрээ байгуулж, ТБҮЦ худалдан авч эхэлсэн байна.

Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны 217/A161 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Засгийн газрын үнэт цаас арилжаалах журам”-ын 1.2.6-д “Шууд оролцогч гэж Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй, өөрийн болон шууд бус оролцогчийн нэрийн өмнөөс ЗГҮЦ худалдан авах, худалдах банкыг хэлнэ” гэж заасан байсан нь 2014 оны Засгийн газрын 371 тоот тогтоолоор батлагдсан “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ын 2.1.3-т “Шууд оролцогч гэж өөрийн болон шууд бус оролцогчийн нэрийн өмнөөс ЗГҮЦ худалдан авах, худалдах эрх бүхий Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдийг” гэж өөрчлөгдсөнөөр брокер дилперийн компаниуд ЗГҮЦ-ны арилжаанд зуучлуулах гэрээ хийж, жижиглэнгийн болон хоёрдагч зах зээлийн арилжаанд оролцож эхэлжээ.

Тус сан 2015 оноос “Би Ди Сек” ҮЦК, “Эм Ай Би Жи” ҮЦК, “Монсек” ҮЦК гэсэн 3 брокер дилперийн компаниудтай ЗГҮЦ-ны арилжаанд зуучлуулах гэрээ хийж, жижиглэнгийн болон хоёрдагч зах зээлийн арилжаанд оролцож эхэлсэн байна.

Сангийн яамнаас 2016 оны 5-8 дугаар саруудад ЗГҮЦ-ны арилжаа явуулаагүй тул ТБҮЦ-нд байршуулах мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

Корпораци нь 2016 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Капитал банктай байгуулсан гэрээг цуцлан мөнгөн хөрөнгөө татан авчээ.

Сангийн яам банкуудтай ЗГҮЦ-ны арилжаанд оролцох 1 жилийн хугацаатай байгуулсан гэрээгээ 2016 онд сунгаагүй тул ЗГҮЦ-ыг банкаар зуучлуулан авах боломжгүй болж, зөвхөн брокер дилперийн компаниар зуучлуулдаг болжээ. 2016 оны эцэст нийт 7 банкаар дамжуулан ТБҮЦ худалдан авч, 1 брокер дилперийн компани буюу “Би Ди Сек” ҮЦК-иар зуучлуулан ЗГҮЦ авдаг болсон байна. “Би Ди

Сек" УЦК-ыг сонгож үлдээх болсон шалтгааныг тодруулахад: "ЗГҮЦ-ы арилжаанд оролцоход, байгууллагын саналыг хэдэн ч брокер диллерийн компаниар дамжуулан өгсөнөөс үл хамааран хуваарилалт хийхдээ санал өгсөн байгууллагын нийт саналыг бүхэлд нь авч үзэж хуваарилдаг байсан тул З компаниар зуучлуулах шаардлагагүй болж, тогтмол ЗГҮЦ-ны мэдээллийг ирүүлдэг, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг "Би Ди Сек" УЦК-иар зуучлуулах болсон" гэсэн тайлбарыг хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн өгсөн.

Тус корпораци нь 2017 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар нийт 7 банкаар зуучлуулан ТБҮЦ, брокер диллерийн 1 компаниар зуучлуулан ЗГҮЦ-ыг худалдан авсан байна.

ХДК сангийн хөрөнгө оруулалтын төсвийг хуулинд заасны дагуу жил бүр ХДК-ын Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцэн баталж иржээ. Хөрөнгө оруулалтын өгөөжийг 2016 оны тесөвт 27.2 тэрбум төгрөгөөр баталсанаас 29.9 тэрбум төгрөг, 2017 онд 28.7 тэрбум төгрөгөөр баталсанаас эхний хагас жилд 20.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарчээ.

Сангийн хөрөнгийн бүтэц, үнэт цаасны орлого, зуучлалын шимтгэл төлөлтийг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Багцын бүтэц	Эхний үлдэгдэл	2016.12.31					2017.6.30				
		Мөнгөн хөрөнгө	Өгөөж, хураамж орлого	Зуучла-лын шимтгэл	ҮЦ-ы санд эзлэх хувь	Мөнгөн хөрөнгө	Өгөөж, хураамж орлого	Зуучла-лын шимтгэл	ҮЦ-ы санд эзлэх хувь		
ЗГБ	94,100.0	63,100.0	10,301.1		23.4%	16,906.4	3,428.0	0.8	5.5%		
ЗГҮЦ	67,639.2	127,825.4	9,231.3	35.9	47.5%	159,406.6	9,327.9	29.5	52.1%		
ТБҮЦ	47,760.0	75,000.0	10,277.4	1,126.1	27.9%	114,400.0	7,701.6	746.3	37.4%		
Бэлэн мөнгө	2,847.8	3,242.5			1.2%	15,076.2			4.9%		
Дүн	212,347.0	269,167.9	29,809.8	1,162.0	100.0%	305,789.2	20,457.6	776.6	100.0%		
Хураамж орлого			28,173.1				16,940.3				
Нийт хөрөнгө	212,347.0	269,167.9	57,982.9	1,162.0	100.0%	305,789.2	37,397.9	776.6	100.0%		

ХДК сангийн хөрөнгө 2016 оны эхэнд 212.3 тэрбум төгрөг байсан бол жилийн эцэст 269.9 тэрбум төгрөг болж өссөн ба үнэт цаасны арилжаанд оролцсон өгөөжийн орлогоор 29.8 тэрбум төгрөг орж, зуучлуулсны шимтгэлд 1.2 тэрбум төгрөг төлсөн, 2017 оны эхний хагас жилийн байдлаар сангийн хөрөнгө 305.8 тэрбум төгрөг болж өссөн ба үнэт цаасны арилжаанд оролцсон өгөөжийн орлогоор

20.5 тэрбум төгрөг орж, зуучлуулсны шимтгэлд 776.6 сая төгрөг төлсөн байна. Үнэт цаасны арилжаанд банкуудаас авсан даатгалын хураамжийн орлогоос 2016 онд 28.2 тэрбум төгрөг, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 16.9 тэрбум төгрөг оруулжээ.

## 2.2. Зардлын гүйцэтгэлийн талаар

Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 24 тоот тогтоолоор ХДК сангийн 2016 оны нийт төсвийг 3,338.2 сая төгрөгөөр, 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 29 тоот тогтоолоор 2017 оны төсвийг 4,446.9 сая төгрөгөөр тус тус тогтоосон байна.

Корпорацийн 2016, 2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/ сая. төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 он			2017 он		
	Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт/ Хэмнэлт	Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт/ Хэмнэлт
Цалин хэлс болон нэмэгдэл урамшуулал	819.5	818.5	1.0	1,120.0	497.4	622.6
Үндсэн цалин	618.6	618.5	0.1	824.1	361.7	462.4
Нэмэгдэл, урамшуулал	159.4	158.7	0.7	237.3	110.4	126.9
Унаа хоолны хенгелөлт	41.5	41.3	0.2	58.6	25.3	33.3
Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	90.1	92.3	-2.2	123.2	54.7	68.5
Байгууллагын тогтмол зардал /түрээс/	203.9	239.0	-35.1	294.4	141.4	153.0
Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	130.9	75.4	55.5	76.3	33.2	43.2
Бичиг хэрэг	10.6	9.1	1.5	11.7	5.3	6.4
Шуудан, холбоо	70.1	12.6	57.4	31.9	9.2	22.7
Тээвэр (шатахуун)	16.7	12.8	3.9	16.3	7.3	9.0
Биеийн тамирын арга хэмжээний зардал	23.5	33.8	-10.3	4.8	3.0	1.7
Хангамжийн материалын зардал	10.0	7.1	2.9	11.7	8.4	3.4
Томилолт, зочны зардал	224.4	219.3	5.1	328.9	95.8	233.1
Дотоод албан томилолт	6.0	0.0	6.0	13.6	0.0	13.6
Гадаад томилолт (арга хэмжээ)	75.0	78.4	-3.4	117.9	85.5	32.4
Зочид төлөвлөгч хүлээн авах зардал	12.0	11.1	0.9	11.8	1.9	9.9
Гадаад, дотоод сургалт, семинарт оролцох зардал	62.6	62.5	0.1	128.0	8.4	119.6
Сургалт, семинар зохион байгуулах зардал	68.7	67.3	1.4	57.5	0.0	57.5
Бусад бараа үйлчилгээний зардал	929.8	1,317.2	-387.4	1,563.5	880.8	682.8
Ургал засварын зардал	22.3	48.4	-26.1	21.6	7.3	14.2
Төлбөр хураамж бусад зардал	35.0	73.2	-38.2	89.9	47.2	42.7
Үнэт цаас худалдан авалтын шимтгэлийн зардал	833.5	1,162.0	-328.5	1,415.1	776.6	638.5
Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээний хэлс (дотоод)	39.0	33.6	5.4	37.0	49.6	-12.6
Ажил олгогчоос олгох тэтгэмж, нэг удаагийн урамшуулал, дэмжлэг	111.3	140.4	-29.1	157.8	146.2	11.6
Нэг удаагийн буцалтгүй тусламж	90.0	90.0	0.0	135.0	135.0	0.0

Төрийн албан хаагчийн гэр бүлд олгох мөнгөн тусламж	15.9	45.0	-29.1	17.4	11.2	6.2
Шагнал, урамшуулал	5.4	5.4	0.0	5.4	0.0	5.4
Даатгалын зардал	34.6	27.8	6.8	52.4	38.1	14.3
Мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээ	194.2	108.5	85.7	130.9	17.4	113.5
Монгол банкнаас авсан зээлийн хүүгийн зардал	599.5	596.5	3.0	599.5	283.2	316.3
<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,338.2</b>	<b>3,634.8</b>	<b>-296.6</b>	<b>4,446.9</b>	<b>2,341.0</b>	<b>2,105.9</b>
Үндсэн орон тоо	22	21		30	30	
Үүнээс: удирдах албан хаагч	2	1		2	2	
Мэргэжлийн албан хаагч	20	20		28	28	

Нийт зардлыг 2016 онд 3,338.2 сая төгрөгөөр төсөвлөснөөс 3,634.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 296.6 сая төгрөгөөр буюу 8.8 хувиар хэтрүүлэн зарцуулсан нь үнэт цаасны хөрөнгө оруулалт нэмэгдэж, төсөвлөсөнөөс 9.8 тэрбум төгрөгөөр илүү орлого олж, үүнийг даган хөрөнгө оруулалтын шимтгэлийн зардал өссөн, түрээсийн болон урсгал засврын зардлууд хэтэрсэн нь 2016 оны 9 дүгээр сарын 1-нээс тус корпораци өөр байранд нүүж орсонтой холбоотой нүүлгэлт, албан тасалгааны тохижуулалт, сервер өрөөний техникийн ажил зэрэг төсөвлөгдөөгүй зардлууд гарсанаас шалтгаалжээ.

Мөнгөн тусламжийн зардлыг 2016 онд 29.1 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь Дэд захирал Ч. Сайнбилэг нь 08 дугаар сарын 30-ны өдөр ажлаас чөлөөлөгдөн 6 сарын тэтгэмж 30.0 сая төгрөгийг олгосонтой холбоотой байна.

Мөн 2017 оны эхний хагас жилд 2,341.0 сая төгрөгийг зарцуулснаас аудитын зардал 12.6 сая төгрөгөөр хэтэрсэн нь “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 27.5-д “Корпораци тухайн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг дараа жилийн 3 дугаар сарын 01-ний дотор Үндэсний хороогоор хэлэлцүүлж, тайланг батлуулна” гэж заасан хугацаанд багтааж аудит хийлгэхийн тулд “PWC АУДИТ” ХХК-тай гэрээний ажил гүйцэтгэх хугацааг шинэчлэн байгуулж, гэрээт ажлын хөлс төлсөнөөс шалтгаалжээ. ҮХ-ны 2017 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар тус зардалд тодотгол оруулж нэмэгдүүлсэн байна.

Хадгаламжийн даатгалын корпораци нь тайлант оны төсөвтөө батлуулан, ажиллагсдын амь нас, эрүүл мэндийн даатгалд нэг хүний 1.3-1.4 сая төгрөгийн хураамж төлөхөөр “Нэйшнл лайф даатгал” ХХК-тэй “Амьдралын даатгалын гэрээ”-г байгуулж, 2016 онд нийт 25.6 сая төгрөг, 2017 онд нийт 29.8 сая төгрөг тус тус төлжээ. “Даатгалын тухай хууль”-ийн 6.2-т “Даатгал нь сайн дурын болон албан журмын гэсэн төрөлтэй байна”, 7.1-д “албан журмын даатгалын хураамжийн хэмжээг Монгол Улсын хуулиар тогтооно” гэж заасан бөгөөд дээрх даатгал нь албан журмын даатгалд орохгүй сайн дурын даатгал бөгөөд мөн тус корпорацийн ажлын

нөхцөл нь Засгийн газрын 1995 оны “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох хөдөлмөрийн нөхцөлийн тухай” 59 тоот тогтоол, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 тоот тушаалаар батлагдсан “Тэтгэврийг хөнгөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д ороогүй хэвийн нөхцөлд хамаарч байгааг судлан үзэж, зардлыг санхүүжүүлэхдээ байгууллага, ажилтнуудын оролцоог тэнцүүлэн сангийн зардлыг бууруулахад анхаарах шаардлагатай байна.

### 2.3. Авлага, өглөгийн талаар

#### Авлага

Хадгаламжийн даатгалын корпораци нь 2016 онд нийт 122.6 тэрбум, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 119.0 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарчээ.

2016, 2017 оны эхний хагас жилийн авлагын үлдэгдлийг харуулбал:

/сая төгрөгөөр/

Авлага	2016 оны эхний үлдэгдэл	2016 онд		2016 оны эцсийн үлдэгдэл	2017.06.30		2017.06.30 -ний үлдэгдэл
		Нэмэгдсэн	Хасагдсан		Нэмэгд- сэн	Хасагд- сан	
Хураамжийн авлага	-	15,699.1	13,763.9	1,935.2	8,269.1	8,303.2	1,901.1
Сангийн яам	7,805.9	0.0	0.0	7,805.9	0.0	0.0	7,805.9
Хувь хүн	4.9	3.1	5.3	2.7	11.0	1.4	12.3
ЧДНДхэлтэс		14.5	13.8	0.7		0.7	0.0
ЧД Татвар		26.3	5.6	20.6		20.6	0.0
Монгол улсын Засгийн газар	1,637.4	10,398.7	10,719.5	1,316.6	3,311.2	4,229.2	398.6
Хадгаламж банкны эрх хүлээн авагч	102,388.1	9,061.3	100.0	111,349.3	0.0	2,500.0	108,849.3
Бусад байгууллага	130.7	295.7	232.4	194.1	29.4	144.3	79.2
<b>НИЙТ</b>	<b>111,966.9</b>	<b>35,457.9</b>	<b>24,821.2</b>	<b>122,603.7</b>	<b>11,620.7</b>	<b>15,178.1</b>	<b>119,046.3</b>

Хураамжтай холбоотой 2017 оны эхний хагас жилд гарсан 1,901.1 сая төгрөгийн авлага нь Голомт, Хаан банкуудаас Хөгжлийн банкны харилцахаас 2013-2015 онуудад төлөх даатгалын хураамж бөгөөд үүнд Голомт банкнаас 1,031.2 сая төгрөг, ХААН банкнаас 869.9 сая төгрөгийн хураамжийг 2016 онд авлагаар үүсгэсэн байна.

Сангийн яамнаас 2013 онд Хадгаламжийн даатгалын корпорацийн эх үүсвэрт олгох 50.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээс олгогдоогүй 7.8 тэрбум төгрөгийн үлдэгдэл, Купонтой Засгийн газрын үнэт цаасны хүүгийн төлбөрийн 398.6 сая төгрөгийн авлага, Хадгаламж банкны эрх хүлээн авагчаас 108.8 тэрбум төгрөгийн авлага, бусад авлага нь байрны түрээс болон шуудан холбоо, бичиг хэргийн зориулалтаар байгууллагад төлсөн 79.2 сая төгрөг, байгууллагын ажилтнуудтай холбоотой 12.3 сая төгрөгийн цалингийн урьдчилгааны авлага байна.

### Өглөг:

Тус корпораци нь 2016 оны эцэст 196.3 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байсан бол 2017 оны эхний хагас жилд 194.1 сая төгрөг болж, 2.2 сая төгрөгөөр буучээ.

2016, 2017 оны эхний хагас жилийн өглөгийг хүснэгтээр харуулбал

/сая төгрөгөөр/

Нэрс	2016 оны эхний үлдэгдэл	2016 онд		2016 оны эцсийн үлдэгдэл	2017 онд		2017 оны эцсийн үлдэгдэл
		Нэмэгдсэн	Хасагдсан		Нэмэгдсэн	Хасагдсан	
Чингис хаан банк	0.0	6.2	2.6	3.6	2.6	6.2	0.0
Монгол банк	11.5	596.5	597.0	11.0	283.2	0.0	294.1
ХХОАТ-ын оглог	1.6	105.5	107.1	0.0	47.5	35.7	11.8
Монголбанкны урт хугацаат зээл	192,938.7	9,061.3	5,700.0	196,299.9	0.0	2,500.0	193,799.9
Цалингийн өглог	0.0	710.4	703.9	6.5	415.4	421.8	0.0
<b>Ишт оглогийн дүн</b>	<b>192,951.8</b>	<b>10,591.3</b>	<b>7,222.1</b>	<b>196,321.0</b>	<b>748.6</b>	<b>2,963.8</b>	<b>194,105.8</b>

Чингис хаан банктай холбоотой 2016 онд үүссэн 3.6 сая төгрөгийн өглөг нь үнэт цаасны шимтгэлийн зардал, Монгол банктай холбоотой 294.1 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл нь Монгол банкинд төлөх 119.9 тэрбум төгрөгийн урт хугацаат зээлийн хүүгийн үлдэгдэл, 193.8 тэрбум төгрөгийн өглөгийн үлдэгдэл нь Монгол банкнаас авсан Төрийн банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр олгосон 119.9 тэрбум төгрөг, Төрийн банкны хувьцааг худалдан авсан 85.0 тэрбум төгрөгийн урт хугацаат зээлийн үлдэгдэл байна.

#### 2.4. Монголбанкнаас зээл, санхүүгийн дэмжлэг олгосон талаар:

##### 2.4.1. Төрийн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний дэмжлэгт зориулсан санхүүгийн дэмжлэг.

Монгол банкны ерөнхийлөгчийн “Хадгаламж банк” ХХК-ийг албадан татан буулгах тухай 2013 оны А/157 дугаар тушаалаар тус банкыг 2013 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс татан буулгасан байна.

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн “Төрийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай” 286 тоот тогтоолоор Төрийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг 85.0 (наян таван) тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, Төрийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор Төрийн банкны энгийн хувьцаа нэмж гарган, Монголбанк эсхүл Хадгаламжийн даатгалын корпорацид худалдахаар санал болгохыг тус тус Сангийн сайдад даалган зөвшөөрсөн байна.

Монгол улсын Сангийн Сайдын 2013 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 185 тоот тушаал, Төрийн банкны ТҮЗ-ийн 2013 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 48 дугаар тогтоолыг үндэслэн Монголбанкны өрөнхийлөгчийн 2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/194 дүгээр тушаалаар Монголбанкнаас ХДК-д буцаан төлөгдөх нөхцөлтэй 85.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг зөвшөөрчээ.

Үүний дагуу Үндэсний хорооны хурлын шийдвэрээр 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 9 тоот тогтоолын дагуу 85,000 ширхэг энгийн хувьцааг худалдан авахыг зөвшөөрснөөр Монголбанк, ХДК-ын хооронд “Монголбанкнаас ХДК-д 0613/446 тоот Санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ”-г 2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр байгуулж, гэрээгээр Төрийн банкны хувьчлалаас ХДК-д ногдох хувьцааны орлогыг барьцаалсан байна.

Мөн “Төрийн банкны хувьцааг худалдан авах гэрээ”-г Төрийн банк, ХДК-ын хооронд 2013 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр байгуулж, 85.0 тэрбум төгрөгөөр Төрийн банкны 1,000,000.00 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 85,000 ширхэг хувьцааг худалдан авч Төрийн банкны хувьцаа эзэмшигч болсон байна.

Дээрх гэрээгээр “Компанийн тухай хууль”-ийн 34.1.1-т заасан саналын эрхийг хэрэгжүүлэх эрх, мөн хуулийн 62 дугаар зүйлд заасан хувьцаа зэмшигчийн эрхийг Сангийн сайдад нэг жилийн хугацаатайгаар жил тутам олгож байхаар зааж, итгэмжлэлийг жил бүрийн 4 дүгээр сарын 17-ны өдөр сунгаж ирсэн байна.

#### **2.4.2. Төрийн банкны актив, пассивын хоорондын зөрүүнд олгосон хөрөнгө**

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А153, А157 дугаар тушаалаар санхүүгийн хүндрэлд орсон Хадгаламж банкинд Эрх хүлээн авагч томилон татан буулгаж, тус банкны актив, пассив хөрөнгийг Төрийн банкинд шилжүүлэхээр шийдвэрлэн, Хадгаламж банкны тодорхой актив, пассив хөрөнгийг Төрийн банкинд шилжүүлснээр тус банкинд үүссэн санхүүгийн чадварын хүндрэлийг шийдвэрлэж, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан, Төрийн банкнаас иргэдэд үзүүлэх банкны болон төрийн санхүүгийн үйлчилгээ хэвийн, тасралтгүй, саадгүй явагдах нөхцлийг бүрдүүлэх шаардлага тулгарсны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/195 тоот тушаалаар ХДК-д 119.9 тэрбум төгрөгийн зээлийг олгох, зээлийн гэрээ, барьцааны гэрээг ХДК-тай байгуулахыг даалгасан байна.

Дээрх тушаалын дагуу Хадгаламжийн даатгалын Үндэсний Хорооны 2013 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын шийдвэр, 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 9 тоот тогтоолоор Монголбанкнаас 119.9 тэрбум төгрөгийг 10 жилийн хугацаатай, жилийн 0.5 хувийн хөнгөлөлттэй хүйтэй зээлийг авч, тус хөрөнгийг Төрийн банкинд үүссэн актив пассивын зөрүүний тооцоог хаахад олгожээ.

Дээрх зээлийг Хадгаламж банкны Эрх хүлээн авагчийн төлүүлсэн активын орлого, Төрийн банкны хувьцааны ногдол ашиг, Төрийн банкны хувьчлалаар Зээлдэгчийн худалдах хувьцааны нэрлэсэн үнээс давсан орлогыг барьцаалан ХДК, Монголбанкны хооронд 2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 0613/445 тоот зээлийн гэрээг байгуулжээ.

Тус гэрээний үндсэн дээр Хадгаламж банкны эрх хүлээн авагчаас мөнгөн хөрөнгөөр 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 10,488.0 сая төгрөг, үйлчилгээний зориулалттай 562.4 сая төгрөгийн өртөгтэй үл хөдлөх хөрөнгө авч, нийт 11,054.0 сая төгрөгийн зээлийг барагдуулсан байна.

Үйлчилгээний зориулалттай нийт 164 м.кв талбай бүхий 562.4 сая төгрөгийн байрыг Эрх шилжүүлэгч Төрийн банк ХХК-ыг төлөөлж Гүйцэтгэх захирал Д.Батсайхан, Эрх шилжүүлэн авагч ХДК-ын Гүйцэтгэх захирал Б.Лхагвасүрэн нар 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 17/823 тоот “Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх” гэрээг байгуулсанаар хөрөнгийг авч данс бүртгэлд тусгаж, орлогод авчээ.

## 2.5. Үндсэн хөрөнгийн талаар

Тус корпораци 2016 оны эхэнд 930.6 сая төгрөгийн хөрөнгөтэй байсан бол тухайн онд 739.4 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 13.7 сая төгрөгийн хөрөнгө хасагдан, оны эцэст 1,656.4 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй гарч, 2017 оны эхний хагас жилд 137.4 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэн, 1,793.7 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

ХДК-ийн нийт үндсэн хөрөнгийн хөдлөлийг хүснэгтээр харуулбал:

Хөрөнгийн нэрс	2016 оны эхний үлдэгдэл	2016 онд		2016 оны эцсийн үлдэгдэл	2017 онд		2017 оны 06.30-ны үлдэгдэл
		нэмэгдсэн	хасагдсан		нэмэгдсэн	хасагдсан	
Барилга байгууламж	562,392.2			562,392.2			562,392.2
Тавилаа эд хогшил	79,807.3	5,741.9	1,400.0	84,149.2	17,637.6		101,786.9
Машин, тоног төхөөрөмж	84,341.0			84,341.0	389.0		84,730.0
Тээврийн хэрэгсэл	138,106.8			138,106.8			138,106.8

Компьютер дагалдах хэрэгсэл	64,794.5	34,656.0	11,799.4	87,651.1	22,050.0		109,701.1
Бусад биет бус хөрөнгө	499.0		499.0				
Програм хангамж	660.0	699,061.6		699,721.6	97,310.1		797,031.7
Нийт хөрөнгийн дүн	930,600.9	739,459.5	13,698.4	1,656,361.9	137,386.7	0.0	1,793,748.7

Корпорацийн 2016 оны худалдан авах хөрөнгийн төсөвт батлагдсаны дагуу нийт 739.5 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсанаас, корпораци нь банкуудаас даатгалд хамааралтай харилцагчдын мэдээллүүдийг цуглуулж сан үүсгэх зориулалтаар "Ай Ти Зон" ХХК-тай 2016 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн IZSLS-16/028 тоот гэрээг байгуулан гэрээний үнээр 2016 онд 698.4 сая төгрөгийг шилжүүлж, хөрөнгөнд орлого авсан байна.

ХДК-ын Гүйцэтгэх захирлын 2016 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 42 тоот тушаалаар 14.9 сая төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хасах тушаал гарсан боловч, 2016 оны жилийн эцэст 11.8 сая төгрөгийн 7 ширхэг компьютерийг акталж данс бүртгэлээс хасч, бусад 3.1 сая төгрөгийн хөрөнгийг 2017 онд акталж, данс бүртгэлээс хассан байна. Мөн 2016 онд үндсэн хөрөнгөнд бүртгэсэн 1.4 сая төгрөгийн автомашины 4 дугуй /ашиглах хугацаа дууссан/, биет бус хөрөнгөнд бүртгэсэн 499.0 мянган төгрөгийн автомашины даатгал /даатгалын хугацаа дууссан/ зэргийг данс бүртгэлээс хасчээ.

2017 оны эхний хагас жилд 137.4 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс 97.3 сая төгрөг нь мэдээллийн сан буюу Оракл программын техникийн лицензийн хураамж байна.

#### Гурав. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Тус байгууллага нь 2014 оны 07 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан "Шилэн дансны тухай хууль"-ийн 3 дугаар зүйлд заасны дагуу шилэн дансны системд бүртгүүлэн, 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс байгууллагын санхүү, болон хуульд заасан бусад мэдээллийг байршуулжээ.

Корпораци нь 2016 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 698.4 сая төгрөгийн 1 тендер, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ 749.1 сая төгрөгийн 34 мэдээлэл, 2017 оны эхний хагас

жилд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 264.3 сая төгрөгийн нийт 18 мэдээллийг тус тус байршуулсан байна.

Харин 2017 онд нийт 6 сарын гүйлгээний мэдээлэл байршуулсан боловч 4 сарын гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож, холбогдох анхан шатны баримт, гэрээ, бусад холбогдох баримтын хамт [info.shilendans.gov.mn](http://info.shilendans.gov.mn) сайтад нөхөж байршуулжээ.

#### **Дөрөв. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын талаар**

Хадгаламжийн даатгалын корпорацийн 2016 он, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар дараах зөрчлүүд гарлаа. Үүнд:

- Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны 2015 оны 12 дугаар сарын 21-ний 25 тоот тогтоолоор Гүйцэтгэх захирал Б.Лхагвасүрэнд 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эрүүл мэндийн шалтгаанаар тодорхойгүй хугацаагаар цалинтай чөлөө олгож /чөлөөний хугацааг заагаагүй/, Дэд захирал Ч.Сайнбилэгт бүрэн эрхийг түр шилжүүлэн дэд захирал нь 2016 оны 1-3 дугаар саруудад эрх зүйн шийдвэр гарган, санхүүгийн баримтанд гарын үсэг зурж байжээ.

Гүйцэтгэх захирал Б.Лхагвасүрэнг ажилдаа буцан орсон талаар эрх зүйн шийдвэр гаргаагүй, мөн чөлөөтэй байх хугацаанд нь хоол унааны хөнгөлөлт, улирлын үр дүнгийн урамшуулал олгосон;

- Корпорацийн гүйцэтгэх захирал Б.Лхагвасүрэн нь 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 47 тоот тушаал гарган Гүйцэтгэх захирлын албан тушаалаас өөрийгөө чөлөөлж, корпорацийн Тамгын хэлтсийн хуульч Б.Амарбилэгийг өөрийн оронд Гүйцэтгэх захирлаар түр хугацаагаар томилсон, мөн Б.Амарбилэгийг гүйцэтгэх захирлаас чөлөөлсөн ямар ч шийдвэр гараагүй байхад Х.Бум-Эрдэнийг Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны 2016 оны 28 тоот тогтоолоор 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс томилсон нь “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 4.1.5-д заасан Корпорацийн гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулж томилох, түүнтэй гэрээ байгуулах, чөлөөлөх, 25.6-д “Энэ хуулийн 22.7.1-д /22.7.1.үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан/ заасан үндэслэлээр Корпорацийн гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тохиолдолд түүний бүрэн эрхийн хугацаа дараагийн гүйцэтгэх захирлыг томилсноор дуусгавар болно”, 25.7-д “Ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, удаан хугацаагаар өвчтэй байх зэрэг тохиолдолд Корпорацийн гүйцэтгэх захирал Үндэсний хорооны зөвшөөрсөн этгээдэд бүрэн

эрхээ шилжүүлж болох бөгөөд ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн;

- Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал Б.Лхагвасүрэнгийн 2016 оны 08 дугаар сарын 29-ний 38 тоот тушаалаар 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 04 тоот тогтоолын 6.2-т “хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлаг нь 100-аас дээш ажилтантай бол дэд дарга (орлогч дарга) 1-тэй, 100-гаас цөөн ажилтантай бол дэд буюу орлогч даргагүй байх чиглэл баримтлах” гэсэн заалтыг үндэслэн дэд захирал Ч.Сайнбилэгийг 2016 оны 9 дүгээр сарын 01-нээс үүрэгт ажлаас нь чөлөөлж, 6 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмжк 30.0 сая төгрөг олгожээ.

Гэтэл Засгийн газрын тогтоолыг үндэслэн Дэд захирлын орон тоог хассан тушаалын дагуу Ч.Сайнбилэгийг чөлөөлж, тэтгэмж олгосон байтал 1 сар гаруй хугацааны дараа Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо нь Засгийн газрын 2016 оны 4 тоот тогтоолыг зөрчин 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 30 тоот тогтоолоор Хадгаламжийн даатгалын корпорацийн ажлын албаны орон тоо 25 байсныг 29 болгон, корпораци Дэд захирлын орон тоотой байхаар баталсан байна.

С.Дамдиндоржийг Дэд захирлаар томилсон Үндэсний хорооны 2016 оны 12 дугаар сарын 26-ны 33 тоот тогтоол нь дээрх Засгийн газрын тогтоолыг зөрчсөн бөгөөд, 18.4 сая төгрөгийн цалин тэтгэмжийг давхардуулан олгосон;

- Монголбанкны өрөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-106/118 тоот тушаалаар батлагдсан “Хадгаламжийн даатгалын Корпорацийн дүрэм”-ийн 3.2-т “Үндэсний хорооны эрх, үүрэг”, 3.2.7-д “гүйцэтгэх захирлын санал болгосноор дэд захирлыг томилох” гэж заасан боловч энэ заалт хэрэгжээгүй дэд захирлыг Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захиралын тушаалаар чөлөөлсөн;

- “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, өрөнхий нягтлан бодогч нар хариуцана” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй. Үүнд:

Тус корпорацийн Хөрөнгийн тооллогын комисс 2016 оны 8 дугаар сарын 11-нд 3 хүний бүрэлдэхүүнтэй тооллого хийж, 14,934.6 мянган төгрөгийн 19 ширхэг эд хөрөнгийг актлах, байгууллагын үйл ажиллагаа, тохижилтонд шаардлагатай 7 ширхэг компьютер худалдан авах санал гаргасан байна.

Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 8 дугаар сарын 29-ний 42 тоот тушаалаар тооллогын комиссын саналыг үндэслэн дээрх хөрөнгүүдийг үнэлэн хамгийн доод үнээр эзэмшиж байсан ажилтнуудад худалдахыг зөвшөөрчээ.

- Гүйцэтгэх захирлын 2016 оны 08 сарын 29-ний 42 тоот тушаалаар актлах хөрөнгүүдийг тооллогын комиссын саналыг үндэслэн тогтоосон хамгийн доод үнээр эзэмшиж байсан ажилтнуудад худалдахыг зөвшөөрсөн боловч үнэлгээг хэн хийсэн нь тодорхойгүй, тушаалын хавсралтаар баталгаажуулаагүй;
- Актлах санал оруулсан хөрөнгөнөөс 2016 оны жилийн эцэст 2013 онд худалдаж авсан ашиглах хугацаа дууссан нэг бүр нь 2,400.0 мянган төгрөгийн үнэтэй Imac маркийн 2 ширхэг компьютер, нэг бүр нь 1,999.9 мянган төгрөгийн үнэтэй Sony L23CFX маркийн 1 ширхэг компьютер, нэг бүр нь 999.9 мянган төгрөгийн үнэтэй Aser AZ1620 маркийн 5 ширхэг компьютер, нийт 11,799.4 мянган төгрөгийн компьютерийг эзэмшиж байсан ажилтнуудад нэг бурийг нь 50.0-75.0 мянган төгрөгөөр үнэлэн борлуулж, 2016 оны жилийн эцэст данс бүртгэлээс хассан;
- Актлах тушаал гарсан нэг бүр нь 999.9 мянган төгрөгийн үнэтэй Aser AZ1620 маркийн 2 ширхэг компьютерийг борлуулаагүй, ашиглах боломжгүй болсон кофе чанагч, ус буцалгагч, 6 ширхэг сандал, цаас хэрчигч зэрэг нийт 1,199.4 мянган төгрөгийн хөрөнгийг 2016 оны жилийн эцэст элэгдлийн хугацаа дуусаагүй гэсэн тайлбартайгаар данс бүртгэлээс хасаагүй, мөн санхүүгийн тайлангийн хугацаанд хуулийн дагуу хөрөнгийн тооллого хийх тушаал огт гаргаагүй, тооллого хийгээгүй;

Тооллогын комиссын саналаар актлах тушаал гарсан боловч 2016 оны жилийн эцсийн тайланд хасаагүй байсан зарим хөрөнгийг шалгалтын хугацаанд 2017 оны жилийн эцсийн тайланд тусгуулав.

- Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2016 оны 04 дүгээр сарын 15-ны 16 тоот тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.1.5-д "корпорацийн ажилтнуудад ажлын өдөрт хоолны мөнгө 6.0 мянган төгрөг, унааны зардалд 1.5 мянган төгрөг тус тус тооцож олгоно" гэж заасан боловч гадаадад томилолтоор явсан ажилтнуудад 2016 онд 23 хүнд нийт 802.5 мянган төгрөг, 2017 оны эхний хагас жилд 9 хүнд нийт 165.0 мянган төгрөг, бүгд 967.5 мянган төгрөг давхардуулан олгосныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох;

- Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал, дэд захирлуудын унадаг албаны машинд сард 500.0-700.0 мянган төгрөгийн шатахуун олгодог боловч “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 4.1.5-д “корпорацийн ажилтнуудад ажлын өдөрт хоолны мөнгө 6.0 мянган төгрөг, унааны зардалд 1.5 мянган төгрөг тус тус тооцож олгоно” гэж заасны дагуу унааны 1.5 мянган төгрөгийг давхар олгож ирснээс 2016 он, 2017 оны эхний хагас жилд нийт 957.0 мянган төгрөг давхардуулан олгосныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоо;

- Капитал банкаар зуучлуулан 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан 20150615-01 тоот “Хөрөнгө оруулалтын зуучлалын гэрээ”-ний дагуу 2016 оны 6 дугаар сарын 6-наас 28 хоногтой 5.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй ТБҮЦ худалдан авсан байснаа хугацаанаас нь өмнө гэрээгээ цуцалж, 2016 оны 6 дугаар сарын 22-нд 16 хоногоор тооцож, цэвэр хүүгийн орлого 20.5 сая төгрөг, ТБҮЦ худалдан авсан 4,976.4 сая төгрөгийг татан авсан байв.

Үүнийг холбогдох мэргэжилтэнгээс тодруулахад: “Хөрөнгө оруулалтын зуучлалын гэрээ”-ний 3.1.1-д “Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг зуучлагчаас шаардах”, 3.1.2-т “Зуучлагчийн эх үүсвэрээр худалдан авсан Төвбанкны үнэт цаасны үлдэгдлийн мэдээллийг тухай бүр шаардах” гэж заасны дагуу Капитал банкнаас дансны хуулга болон ТБҮЦ-ны арилжааны дансны хуулгыг явуулах хүсэлтийг удаа дараа тавьсан боловч хариуг эргэн мэдэгдээгүй, мөн албан бус эх сурвалжаас тус банк сангаас байршуулсан мөнгөн хөрөнгөөр Төв банкны үнэт цаас худалдан аваагүй, өөр зорилгоор ашиглаж байж болзошгүй гэж үзсэн тул “Хөрөнгө оруулалтын зуучлалын гэрээ”-ний 6.1.-д “Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ” гэж заасны дагуу гэрээгээ хугацаанаас өмнө цуцалсан гэсэн тайлбарыг өгөв.

Энэхүү тайлбарт дурдсан асуудлуудыг нэг ч удаа 2 байгууллага хоорондоо болон холбогдох байгууллагуудад албан бичгээр хандаж шийдвэрлээгүй, гэрээг албан ёсоор цуцлаагүй нь “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 21.1.3-т “хадгаламжийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой, эсхүл даатгалын тохиолдлын магадлалыг үнэлэхэд шаардлагатай гэж үзвэл банкинд хяналт шалгالت хийлгэх хүсэлтийг Монголбанкинд тавих” гэсэн заалтыг зөрчсөн;

- Тус корпораци нь “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн 19.7-д “Корпораци дотоод хяналтын албатай байх

бөгөөд дотоод хяналтын алба Хадгаламжийн даатгалын Үндэсний хороонд ажлаа тайлагнана", мөн 24 дүгээр зүйлийн 24.1.10-д "Үндэсний хороо корпорацийн дотоод хяналтын албаны шалгалтын дүнг хэлэлцэж, шийдвэр гаргах" гэсэн заалтыг шалгалтанд хамрагдсан хугацаанд хэрэгжүүлж ажиллаагүй;

- Үндэсний хорооны нарийн бичгийн дарга хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлтийг гаргаж ажиллаагүй нь Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны ажиллах журмын 6 дугаар зүйлийн 6.6.6-д "Үндэсний хорооны нарийн бичгийн дарга Үндэсний хорооны хуралдааны шийдвэрийн биелэлтийг улирал бүр гарган хорооны хуралд танилцуулах" гэсэн заалтыг зөрчсөн;
- ХААН, Голомт банкуудад байршиж буй Хөгжлийн банкны харилцах хадгаламжаас даатгалын хураамжийг төлүүлээгүй, авлагыг нэмэгдүүлсэн нь "Банкин дахь хадгаламжийн даатгалын тухай хууль"-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т "хадгаламж" гэж "Банкны тухай хууль"-д заасан харилцах болон мөнгөн хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгийг хэлнэ" гэж заасныг зөрчиж, нийт 1,901.1 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь "Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль"-ийн 5 дугаар зүйлийн 5.1. заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлэх;
- "Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль"-ийн 22 дугаар зүйлийн 22.5-д "Үндэсний хорооны дарга болон Корпорацийн гүйцэтгэх захирлаас бусад гишүүний урамшууллын хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална" гэж заасны дагуу Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн А-130/170 тоот тушаалаар Үндэсний хорооны гишүүдийн урамшууллын хэмжээг ХДК-ын 2014 оны төсвийг үндэслэн 1,500.0 мянган төгрөгөөр тогтоосон байх бөгөөд бусад онуудад урамшууллын хэмжээг тогтоож тогтоол гаргаагүй, дээрх хэмжээгээр олгож ирсэн байна.

Шалгалтын хугацаанд гадаад томилолтын тайлан тооцоог шалгахад томилолтоор ажиллах тухайн байгууллагаас ирүүлсэн сургалт, уулзалт, хурлын хетэлбөр дутуу, томилолтоор ажилласан тайлан, илтгэх хуудас, томилолтын зардлын зарцуулалтын баримт дутуу байсныг шалгалтын хугацаанд холбогдох ажилтнуудаас асууж тодруулан, баримтын бүрдэл хангуулж, тус корпорацийн

мэргэжилтнүүд болон санхүү бүртгэлийн ажилтнуудад мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч ажиллаа.

### Тав. Дүгнэлт.

Хадгаламжийн даатгалын корпораци сан нь 2013 онд 85.0 тэрбум төгрөгийн эхлэлтийн хөрөнгөтэй үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт орлого 298.4 тэрбум төгрөгт хүрч сангийн хөрөнгө нэмэгдэж, жил бүр төлөвлөсөн хэмжээнээс давуулан биелүүлж ирсэн байна.

Хадгаламжийн даатгалын корпораци сан нь “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-д заасны дагуу корпорацийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгчид хугацаанд нь хүргүүлж ирсэн байна.

Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын тушаалаар баталсан заавар журам, аргачлалыг баримтлан санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/-ын дагуу санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад тайлагнаж иржээ.

Хадгаламжийн даатгалын корпораци нь байгуулагдсанаасаа хойш үндсэн үйл ажиллагааг сайжруулах өргөжүүлэх талаар тодорхой ажлуудыг жил дараалан хийж байгаа боловч корпорацийн дотоод албан ажилд анхаарч сайжруулах асуудлууд нилээдгүй байна. Тухайлбал, Хөдөлмөрийн дотоод журам болон, ажилтнуудын ажлын ур чадвар, үр дүнг дүгнэх, үнэлэх, урамшуулах журмыг боловсронгуй болгож, Үндэсний хороо болон Гүйцэтгэх захирлын гаргаж буй эрх зүйн баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн журам зааварт нийцүүлэн гаргаж байх нь зүйтэй байна.

Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо нь Гүйцэтгэх захирлыг түр болон бүр чөлөөлөх, түр үүрэг гүйцэтгэгчийн эрхийг цуцлах, цалин хөлсний хэмжээ, эрх, үүргийн хязгаарыг тогтоошийдвэрийг тухай бүр тодорхой гаргах хэрэгтэй байна. Мөн “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”, “Хадгаламжийн даатгалын корпорацийн дурэм”-д Гүйцэтгэх захирлын эрх үүргийг тусгасан байгаа боловч, сангийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан тохиолдолд тооцох хариуцлагын талаар огт тусгагдаагүй байна.

Хөдөлмөрийн дотоод журамд ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар нилээд асуудлыг зааж оруулсан байгаа боловч орон сууцны дэмжлэг үзүүлэх, нэхцэл сайжруулах, дараалал тогтооши талаар тодорхой болгон, дээрхи

дэмжлэгийг үзүүлэхдээ /шударга ёсны зарчмыг баримтлан/ баримтлах чиглэл, ажилтнуудад тавигдах шалгуур үзүүлэлтүүдийг оновчтой тогтоон, нарийвчлан зааглаагүй тодорхой бус байгаа нь шийдвэр гаргахад төвөгтэй төдийгүй, тэдний дунд маргаан үүсэх, үл ойлголцол буй болох, дарга удирдлагадаа итгэх итгэл алдрах, шударга ёс, тэгш байдлын зарчим алдагдах зэрэг сөрөг дагавар үүсэхээс урьдчилан сэргийлж, анхаарах шаардлагатай байна.

Монголбанкинд буцаан төлөх Хадгаламж банкны эрх хүлээн авагч Төрийн банкинд 2013 онд олгосон 119.9 тэрбум төгрөгийн зээлийн авлагаас 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 11.1 тэрбум төгрөгийн өрийг барагдуулснаас харахад зээл олгогдоод 4 жил гаруй хугацаа өнгөрөхөд эргэн төлөлт дөнгөж 9.2 хувьтай байгаа нь зээлийн төлөлт хангалтгүй байгааг харуулж байна. Төрийн банкны хувьчлалаас дээрх зээлийг төлөхөөр барьцаа болгосон ч тус банкны хувьчлал тодорхойгүйгээс уг зээлийн үлдэгдлийг цаашид ямар замаар төлөх нь тодорхой бус болж, тус ХДК-д авлага, өглөгийг зохиомлоор үүсгэж, санхүүгийн үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлөх үзүүлэлт болсон байна.

Тус корпораци /сан/ даатгалын хураамжийн орлогыг бүрдүүлэхдээ банкуудын хадгаламжийн үлдэгдэлд шууд хяналт тавих хууль эрх зүйн зохицуулалтгүйгээс Монгол банкнаас банкуудын тайланг авч, тус корпорацид банкуудаас ирүүлсэн мэдээтэй тулган хураамжийг төвлөрүүлж байна.

Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо нь корпорацийн үйл ажиллагаа болон төсөв хөрөнгийн талаарх эрх зүйн шийдвэрийг гаргаж байгаа ч тус хороо нь жилд 3-аас доошгүй удаа хуралддаг /зарим жилд 1 удаа/-аас харахад байнгын бус ажиллагаатай тул гүйцэтгэж буй ажил, үүрэг, ажиллах хугацаатай нь уялдуулан урамшууллыг олговол /жилд 72.0-84.2 сая төгрөг олгож байна/ зардлыг бууруулах нэг нөхцөл болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 2.1-д "Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсын эрдэнэсийн сан, Ирээдүйн өв сангийн бүрдүүлэлт, хуваарилалт, захиран зарцуулалттай болон Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Ирээдүйн өв сан корпорацийн болон Малын индексжуулсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад үйлчлэхгүй" гэсэн байхад "Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль"-ийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Хадгаламжийн даатгалын корпораци нь хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг эрхлэх тусгайлсан чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус, төрийн өмчит хуулийн этгээд байна", мөн Төрийн

болов орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “улсын төсвийн хөрөнгө болон төрийн бусад тусгай сан” гэж заасан, корпорацийн санхүүгийн эх үүсвэр нь улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн зэргээс харахад өмчийн харилцааг зохицуулах хуулийн заалтууд хоорондоо зөрчилдсөнөөс тус байгууллагад өмчийн харилцааны асуудал тодорхой бус явж иржээ.

### **Зургаа. Цаашид авах арга хэмжээний талаар**

#### **Хадгаламжийн даатгалын Үндэсний хороонд:**

- Гүйцэтгэх захирал, дэд захирал, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийг томилох, чөлөөлөх хугацаа болон цалин хөлсний хэмжээг тодорхой тогтоосон шийдвэр гаргах, мөн дээрх албан тушаалтнуудад үр дүнгийн урамшуулалт олгох журам гаргаж, мөрдөх;
- Гүйцэтгэх захирал сангийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан тохиолдолд тооцох хариуцлагыг тодорхой болгох;
- Үндэсний хороо нь байнгын бус үйл ажиллагаатай бөгөөд зардлыг багасгах үүднээс гишүүдэд хуралдсан /ажилласан/ хугацаанд нь урамшуулалт олгож байх.

#### **Хадгаламжийн даатгалын корпорацид:**

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан шинэчлэн боловсруулж, Сангийн сайдын 2015 оны 341 тоот тушаалаар баталсан журам, маягт, аргачлалыг тусгах, мөн орлого зарлагын эдийн засгийн ангиллыг тодорхой болгон баталж мөрдөх;
- Байгууллагын дотоод хяналтыг сайжруулж, мэргэжлийн дадлага туршлагатай боловсон хүчинээр бэхжүүлэх;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын талаар гарсан эрх зүйн актуудтай нийцүүлэн өмчийн харилцааг зохицуулах, нягтлан бодох бүртгэлд тусгах, данс бүртгэлээс хасах зэрэг асуудлыг тодорхой тусган оруулж Хадгаламжийн даатгалын Үндэсний хороогоор батлуулан, мөрдөж ажиллах;
- Ажилтнуудын ажлын үр чадвар, үр дүнг үнэлэхдээ нийтлэг үзүүлэлтээр үнэлж байгаагаас гадна гүйцэтгэж буй ажил, албан тушаалын онцлогийг харгалзах шалгуур үзүүлэлтийг нарийвчлан гаргаж журамд тодорхой тусгах;
- Албан хэрэг хөтлөлтийн заавар журмыг мөрдөж ажиллах;
- ААНБ, иргэдтэй хийсэн гэрээний биелэлтийг гаргаж, тооцоо нийлж байх;

- Гадаад томилолтоор ажиллах хугацаанд давхардуулан олгосон унаа, хоолны зардал, мөн албан тушаалын унаа хэрэглэдэг ажилтнуудад давхардуулан олгосон унааны зардал, нийт 1,924.5 мянган төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлэх;
- Монголбанкинд төлөх зээлийн төлөлтийг цаашид хэрхэн барагдуулах талаар холбогдох байгууллагуудтай зөвшилцэн шийдвэрлүүлэх;
- ХААН, Голомт банкнаас авах даатгалын хураамжийн 1,901.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах;
- Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтонд тавигдах шалгуурыг нарийвчлан тогтоож, ажлын ачаалал болон үр дүнтэй нь уялдуулж орон тоог батлан, цалин хөлсийг тогтоох;
- Банкуудын харилцах, хадгаламжийн үлдэгдэлд шууд хяналт тавих хууль эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх талаар анхаарч ажиллан, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар төлөвлөгөө гарган, тодорхой албан тушаалтнуудад хариуцуулан, биелэлтийг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт 2018 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэхийг Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирал /Х.Бум-Эрдэнэ/-д үүрэг болгож байна.

#### ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

**БИЧСЭН:**  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Д.ГЭРЭЛ

УЛСЫН БАЙЦААГЧ

Б.ЭНХТУЯА




**ТАНИЛСАН:**  
ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН  
КОРПОРАЦИИН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Х.БУМ-ЭРДЭНЭ

АХЛАХ НЯГЛАН БОДОГЧ:

Г.БАТ-ЭРДЭНЭ





Г ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН Г  
КОРПОРАЦИД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзандийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018-д. 12 № 13.1/731  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Дотоод аудитын хорооны Г  
тогтоол хүргүүлэх тухай

Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу ХДК /сан/-ийн 2016, 2017 оны эхний хагас жилийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг Сангийн яамны Дотоод аудитын хорооны 2018 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар хэлэлцэн 15 тоот тогтоолоор батлагдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Тогтоолоор өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах төлөвлөгөө боловсруулан 2018 оны 3 дугаар сарын 05-ны дотор ирүүлж, төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт тайлагнаж ажиллана уу.

Жич: Дотоод аудитын хорооны тогтоолыг хавсаргав.

САНХҮҮГИЙН ХЯНАТ, ЭРСДЭЛИЙН  
УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГА

Н.НАРАНГЭРЭЛ

УУДАС011 0531787



САНГИЙН ЯАМНЫ ДОТООД АУДИТЫН  
ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 02 сарын 08 өдөр

Дугаар: 15

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.7, Дотоод аудитын хорооны 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ нь**:

**Нэг.** Хадгаламжийн даатгалын корпорац /сан/-ийн 2016 он, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнг хэлэлцээд шийдвэрлэх хүрээнд:

Шалгалтаар илэрсэн зөрчилд Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн тогтоосон 1.9 сая төгрөгийг нөхөн төлүүлэх акт, мөн 1,901.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгсөнийг хугацаанд нь барагдуулж ажиллахыг даалгасугай.

Хадгаламжийн даатгалын корпораци /сан/-ийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг засч арилгах, давтан гаргахгүй байх талаар бүх талын арга хэмжээ авч, зөрчлийг арилгах төлөвлөгөө гарган, байнгын хяналт тавьж ажиллах, мөн дараах асуудлуудад анхаарч ажиллахыг Зөвлөмж болгож байна. Үүнд:

**Хадгаламжийн даатгалын Үндэсний хороонд:**

- Гүйцэтгэх захирал, дэд захирал, гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийг томилох, чөлөөлөх хугацаа болон цалин хөлсний хэмжээг тодорхой тогтоосон шийдвэр гаргах, мөн дээрх албан тушаалтнуудад үр дүнгийн урамшуулалт олгох журам гаргаж, мөрдөх;
- Сангийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан тохиолдолд Гүйцэтгэх захиралд тооцох хариуцлагыг тодорхой болгох;
- Үндэсний хороо нь байнгын бус үйл ажиллагаатай бөгөөд зардлыг багасгах үүднээс гишүүдэд олгож буй урамшууллыг хуралдсан /ажилласан/ хугацаанд нь олгож байх.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, дүн шинжилгээ хийж, Дотоод аудитын хороонд эргэн танилцуулахыг Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт үүрэг болгосугай.

